

Хонхор тосгоны хүн эмнэлэг

Тус эмнэлэг нь 1960 онд Төр хурахын үслэг ангийн аж ахуйг түшиглэн анх их эмчийн салбар нэртэйгээр байгуулагдан 48 дахь жилдээ тус хорооны иргэдэд эмнэлгийн анхан шатны тусламж үйлчилгээг үзүүлж байна.

1991- ээс-1993 он хүртэл салбарын эрхлэгчээр З.Цэмбээ, 1999-2001 он хүртэл Д.Батсуурь, 2001-2002 он хүртэл Л.Одонтуяа, 2002-2005 он хүртэл С.Мөнхзул, 2005 оноос одоог хүртэл эрхлэгч эмчээр Л.Туяа ажиллаж байна. 1981 онд Хонхрын төвд эмнэлгийн нэг давхар барилга баригдсан. Одоо 12 ортой ажиллаж байна. 2000 онд эмнэлгийн түргэн тусламжийн авто машинтай болсон. 2005 онд мэргэжлийн лаборанттай лаборатори ажиллаж цус шээсний ерөнхий шинжилгээ,мазок, цагаан хорхойн шинжилгээ хийж байна.

2006 оноос 13 сая төгрөгийн эргэлттэй 183 нэр төрлийн эмийн фондтой эмийн сан тосгоны иргэдэд үндэсний зайлшгүй шаардлагатай эмээр үйлчилж байна.

ДЗОУБ-ын хөрөнгө оруулалтаар сийрэгжүүлэлтийг кабинет байгуулан зундаа 50-60 хүүхдэд чийрэгжүүлэх хийгддэг Байгуулагдсанаас 2000 он хүртэл 1 их эмч ажиллаж байснаа 2001 оноос 3 их эмч болж, 8-н дунд мэргэжилтэнтэй ажиллаж ирлээ. Мэргэжилтэй боловсон хүчний хангалт 80% тай байна. Их бага эмч нар төгсөлтийн дараа хи,сургалт анд 100% хамрагдаж жилдээ авах кредитээ бүрэн биелүүлдэг. 2006 оноос эмнэлгийн захиргаа, санхүү, дүн бүртгэл цахим мэдээллийн сантай иж бүрэн компьютерээр хангагдсан.Олон улсын санхүү бүртгэлийн програмын дагуу санхүүгийн үйл ажиллагаа явагддаг.

Үйлчлэх хүрээний хүн ам нь 3800,980 өрхтэй, үүнээс 0-1 насны хүүхэд -78, төрөх насны эмэгтэйчүүдийн 1012, өндөр настан 462 хүнд эмнэлгийн анхан шатны тусламж үйлчилгээ болон нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлдэг. Туул тосгоны эмнэлэг нь нийт 21 ажилчинтай үүнээс их эмч 3, эмнэлгийн дунд мэргэжилтэн -9, бусад туслах ажилчин 9 тэй үйл ажиллагаагаа явуулж байна.

Эмнэлэг нь 78753.1 сая төгрөгийн төсвөөр санхүүждэг ба эмнэлгийн тоног төхөөрөмжийн хангалт 70,3% тай 2004 оны 12-р сард магадлан итгэмжлэлээ 3 жилээр сунгуулсан. 2007 оны байдлаар эмнэлэгт 474 хүн хэвтэн эмчлүүлж 3376 ор хоног ашиглаж, дундаж ор хоног 7,1 байна.

2007 онд нийт үзлэг 8598 хийсний 3127 нь урьдчилан сэргийлэх,1414 гэрийн идэвхтэй эргэлт, 2918 өвчний учир амбулаторийн үзлэг, 758-р гэрийн дуудлага,381 диспансерын хяналтын өвчтөн үзэж үйлчилсэн ба 520 өвчлөл бүртгэгдсэн байна. 100 эх жирэмсний хяналтанд авсны 84,6% нь, буюу 84 эх 3 сартайд хяналтад авч хянасан ба жирэмсний болон төрөх үеийн хүндрэл гараагүй Товлолын дагуу хийгдэх вакцины хамралтын хувь 99,2% ай ба хамрагдвал зохих 395 хүүхдээс 392 хүүхэд хамрагдсан. Халдварт өвчний 35 тохиолдол илэрсэн байна. Эмнэлгийн тоног төхөөрөмжийн хувьд MNS-5095-2001 стандартын дагуу мэс заслын багаж, цусанд сахар тодорхойлох аппарат,кварцын ламп, болон тусгаарлах өрөөнд байвал зохих багаж хэрэгсэл бүрдүүлсэн Нийт мэргэжлийн ажилчид бүгд лицензтэй бөгөөд эмч нар 69 багц сургалт, сувилагч нар 46 багц сургалт-анд суусан байна.

Зорилт: Монгол Улсын Эрүүл мэндийн Сайдын 2006 оны 135 дугаар тушаалаар батлагдсан "Эмнэлгийн мэргэжилтний ёс зүй сахилга, хариуцлага, харилцаа хандлагыг улам сайжруулах

2.Эмнэлгийн мэргэжилтний мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх тасралтгүй

Удирдлага бүтэц зохион байгуулалт : 1. Ерөнхий эмч, Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанарын алба: Салбарын эрхлэгч, Их эмч, Эмийн сангийн хэсэг, Лабораторийн хэсэг, Халдвар судлалын хэсэг,

2.Хүний нөөц, Статистик мэдээлэл зүй,

3. Санхүү, аж ахуйн, нийтлэг үйлчилгээний алба, нярав,нягтлан бодогч, тогооч

4.Сувилахуйн тусламж үйлчилгээний, Ээлжийн сувилагч, Вакцинатор сувилагч, Өрхийн сувилагч суралцах орчинг бүрдүүлснээр тусламж үйлчилгээний чанар стандартын хэрэгжилтийг бүрэн хангах

3. Ээлтэй орчинд ёс суртахуунтай, соёлтой үйлчилгээ нэвтрүүлэхэд байгууллагын захиргаа, хамт олны анхаарлыг төвлөрүүлэх

Үйл ажиллагааны чиглэл

Иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгож амьдрах зөв дадалд сургах

Эх, нярайн анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлэх

Сувилахуйн тусламж үйлчилгээ

НҮЭМ-ийн хөтөлбөр хэрэгжүүлэх

Эх, эмэгтэйчүүдэд эрүүл мэндийн /нөхөн үржихүйн/ боловсрол олгох

Харьяа нутаг дэвсгэрийн хүн амд эмнэлгийн анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлдэг.

Хүний нөөцийн мэдээлэл : Манай эмнэлгийн эрхэм зорилго,зорилт, уриаг хэрэгжүүлэх хамгийн чухал нөөц нь хүний нөөц юм.

Зорилго: Манай эмнэлгийн хүний нөөцийн төлөвлөлт, бүтэц бүрэлдэхүүн, хөгжил сургалт, хуваарилалт, удирдлага зохион байгуулалтыг боловсронгуй болгох, эмнэлгийн мэргэжилтнүүдийн мэдлэг, мэргэжлийг тасралтгүй дээшлүүлэх, тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлийг улам баталгаажуулах замаар эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлэх, чанар хүртээмжийг сайжруулан хөврөх чадвартай хүний нөөцийг бүрдүүлэхэд оршино.

Тус эмнэлэг нь 3 их эмч 2 бага эмч, 6 сувилагч,эм найруулагч -1, лаборант 1, ариутгагч 1, асрагч 4, нягтлан бодогч, жолооч, слесарь, гэсэн 21 эмнэлгийн мэргэжилтэн, албан хаагчдын бүрэлдэхүүнтэй Баянзүрх дүүргийн 11 хорооны иргэдэд эмнэлгийн анхан шатны тусламж үйлчилгээг үзүүлдэг.

Удирдах ажилтан -1

Их эмч - 2

Сувилагч -6

Бага эмч- 2

Бусад ажилтан- 10

Хамтын ажиллагаа

Дэлхийн Зөн Олон улсын байгууллагын АОНХХ-тэй 2002 оноос хойш хамтран ажиллаж байна.

Эмнэлгийн эрхэм зорилгыг хэрэгжүүлэхэд байнгын дэмжлэг туслалцаа үзүүлдэг.